



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 1/337

Мандалговь

Хөдөө аж ахуйн салбар болон төв,
суурин газрын 2022-2023 оны өвөлжилт,
хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.11, 27.5.12, 27.5.14, 27.5.16 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 277 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурин газрын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай" аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 18-ний өдрийн 03 тоот албан даалгавар, 2022-2023 оны аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 20-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 23-ны дотор хангаж, тайланг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Засгийн газрын тогтоол, албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажил зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих, шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж, дүн мэдээг 10 дугаар сарын 26-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)- т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4822111137